

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
ИДЭРХҮҮГИЙН НОМИНЗУЛЫН 2024 ОНЫ СҮҮЛИЙН
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. "Хилийн боомтод хуулийн дагуу гадаадын иргэдэд виз олгох, бүртгэл, хасалт хийх" зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Хилийн боомтод визгүй ирсэн гадаадын иргэнд зохих ангиллын виз холбогдох журамд нийцүүлэн олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох, оршин суух зөвшөөрлийн хасалт хийх, материал хүлээн авах	Олгосон виз олголтын хэрэгжилтийн хувь	-	100%	Хагас жилийн байдлаар цахимаар К2, К4, К6 ангиллын визийг 10 орны 1790 гадаадын иргэнд олгож ажилласан.	03.07 - 11.29	80
2.	Арга хэмжээ 1.2. Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл, Монгол Улсын харьяат болох харьяатаас гарах, иргэний харьяаллын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх	Хяналт тавьж, бүртгэлийн хэрэгжилтийн хувь	-	100%	Call Pro 1800-1882 зөвлөгөө мэдээллийн утсанд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн талаар 779 дуудлагад зөвлөгөө мэдээлэл өгсөн. Монгол улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн F1 ангиллаар монгол улсад оршин суух хугацааг сунгах хүсэлт явуулсны дагуу амьдрах нөхцөл, эрхэлж буй ажлын объектийн судалгаанд оролцож, ХУАБ Б.Эрдэнэтуяагийн хамт шалгалт хийж, тухайн шалгалтад зураг баримт цуглуулж, мэдээлэл авч оролцсон. Мөн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан гадаадын иргэн, аж ахуй нэгжид хяналт шалгалтын явцад оршин суух зөвшөөрөл, визтэй холбоотой	03.07 - 11.29	80

1	2	3	4	5	6	7	8
					асуудлаар зөрчил гаргахаас сэргийлэх болон тухайн асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.		
3.	Арга хэмжээ 1.3 Хилийн боомтоор зорчих болон хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй гадаад иргэдийн бүртгэлийг хөтөлж, хяналт тавих	Хяналт тавьж, бүртгэлийн хэрэгжилтийн хувь	-	100%	Жилийн эцсийн байдлаар ХОЗҮ үнэмлэхтэй гадаадын иргэний хилээр нэвтэрсэн хөдөлгөөнийг өдөр бүр бүртгэж, мэдээ бэлтгэн бүсийн тайланд тусгуулах байдлаар тоон мэдээ гарган ажиллаж байна.	03.07 - 11.29	80
Зорилт 2. Хууль тогтоомжийн дагуу аймаг орон нутгийнхаа хэмжээнд хяналт тавьж ажиллах" зорилтын хүрээнд							
4.	Арга хэмжээ 2.1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тухайн харьяалах бүс нутагт холбогдох албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж, гадаадын иргэний бичиг баримтад үзлэг шалгалт хийх	Хяналтын хэрэгжилтийн хувь	-	100%	2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн бүсийн даргын баталсан 16/27 дугаар удирдамжын дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар 9 байгууллагын 153 гадаадын иргэний баримт бичигт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар зөрчилтэй 1 аж ахуй нэгжийн 2 иргэн (уригч аж ахуй нэгж нь гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд аваагүй)-ий зөрчил илэрсэн.	03.07 - 11.29	80
5.	Арга хэмжээ 2.2. Хилийн боомт, орон нутагт зорчих гадаадын иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд гадаадын иргэнтэй ярилцлага хийж тэмдэглэл хөтлөн баталгаа гаргуулах	Хяналт тавьсан гадаад иргэдийн тоо	-	100%	Тайлант хугацаанд Ульхан, Эрээнцав боомтоор нийт 4 улсын 1139 гадаадын иргэн хил нэвтэрсний баримт бичигт үзлэг шалгалт хийж ISF системд шүүлт хийж зорчигч гадаадын иргэн тус бүрт албадан, хориг, тусгай тэмдэглэлд шалгасан. Хилээр нэвтэрсэн нийт гадаадын иргэдийн нэгдсэн мэдээг хөтлөн удирдлагад танилцуулсан. IV улирлын байдлаар бүсийн хэмжээнд боомтуудаар давхардсан тоогоор 37532 гадаадын иргэн зорчиж, 187 иргэн хил дээрээс буцаагдаж, хилийн боомт дээр 295 виз олгогдсон ба тэдгээрийн мэдээг виз, виз зөвшөөрлийн газарт сарын мэдээг нэгтгэж хүргүүлэн, бүсийн жилийн эцсийн тайланд нэгдсэн тоо мэдээ гаргаж ажиллаж байна.	03.07 - 11.29	80

1	2	3	4	5	6	7	8
6.	Арга хэмжээ 2.3. Тухайн орон нутагт оршин суугч гадаадын иргэний бүртгэлийг хөтөлж, орон нутгийн төмөр зам болон авто зам, агаарын тээврийн хэрэгслээр зорчигч гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт шалгалт хийх	Хамтран ажилласан талаарх илтгэх хуудасны тоо	-	100%	Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй хууль, хяналтын байгууллага болох Хил хамгаалах байгууллага, Гааль, тагнуулын байгууллагатай хамтран боомтын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, боомт хуваарын дагуу, албаны үйл ажиллагаа хэвийн тасралтгүй явагдсан. Ульхан боомтод ажиллах хугацаанд тогны хязгаарлалттайн улмаас хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх албаны сервер тоггүй болоход Зүүн бүс дэх газрын цахилгаан моторыг албан хэрэгцээнд ашиглаж, боомтын үйл ажиллагааг тасралтгүй ажиллуулахад харилцан туслалцаа үзүүлж ажилласан.	03.07 - 11.29	80
Зорилт 3. "Зөрчил гаргасан уригч, гадаадын иргэний талаар мэдээллийн сан бүрдүүлэх, зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх" зорилтын хүрээнд							
7.	Арга хэмжээ 3.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн зөрчлийг шийдвэрлэж, шийтгэл оногдуулах, мэдээллийн санд бүртгэх, зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд зөрчил арилгуулах талаар албан шаардлага гаргах, гарах сануулга өгөх, хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах талаар	Холбогдох хууль тогтоомжийн дагуу зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд арга хэмжээ авч, хяналт тавьсан гүйцэтгэлийн хувь	-	100%	Оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн болон монгол улсын нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн 1 иргэн, 1 уригч аж ахуй нэгж үйлдсэн зөрчлөө сайн дураар өөрөө илчилж ирсэн зөрчлийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Мөн 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн бүсийн даргын 16/27 дугаар удирдамжын дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар 9	03.07 - 11.29	

1	2	3	4	5	6	7	8
	дүгнэлт үйлдэх, албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах				байгууллагын 153 гадаадын иргэний баримт бичигт хяналт шалгалт хийхэд БНХАУ-ын 2 иргэний оршин суух зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд аваагүй уригч аж ахуй нэгжийн зөрчлийг шийдвэрлэн, 240000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг тус бүрийг зөрчлийн мэдээллийн санд бүртгүүлж, зохих байгууллагын хяналтад шилжүүлсэн. Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан бүсэд харьяалагдах гадаад иргэн авч ажиллуулдаг байгууллагуудад хийгдсэн шалгалтын тэмдэглэлд үндэслэн 18 аж ахуй нэгж байгууллагын судалгааны сайтад баяжуулалт хийсэн.		80
8.	Арга хэмжээ 3.2. Монгол улсаас албадан гаргасан, гарахыг түдгэлзүүлсэн, орохыг хориглосон гадаад иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих	Хууль зөрчсөн иргэнд авсан хориг арга хэмжээний хувь		100%	Тайлант хугацаанд 1790 гадаадын иргэнд цахим виз олгоход албадан гаргасан болон гарахыг түдгэлзүүлсэн, орохыг хориглосон тусгай тэмдэглэлтэй, хоригтой гадаадын иргэний мэдээлэлд immigration сайтад тус бүр шалгаж, хайлтад илэрцтэй гадаадын иргэнийг удирдлагад мэдэгдэн цахим виз олгохоос татгалзах болон виз зөвшөөрлийн газарт шилжүүлэх байдлаар ажилласан. Хилийн боомтод ажиллах хугацаанд Эрэнцав, Ульхан боомтоор зорчигч гадаадын иргэдийн мэдээллийг immigration сайтад шалгаж хилээр нэвтрүүлсэн.	03.07 - 11.29	80
Зорилт 4. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд							
9.	Арга хэмжээ 4.1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Монгол Улсын	Хууль, тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, үндсэн чиг үүргээ			Холбогдох хууль, тогтоомж болон бусад дүрэм, журмыг өдөр тутамд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна.		

1	2	3	4	5	6	7	8
	хилийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Архивын тухай, Нийтийн албанд, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	хэрэгжүүлж, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100%		03.07 - 11.29	90
10.	Арга хэмжээ 4.2. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох	Оролцсон арга хэмжээний тоо	-	100%	"IMMIGRATION-Спорт наадам 2024" олон төрөлт тэмцээнд оролцож, сагсан бөмбөгийн төрөлд алт, волейболын төрөлд хүрэл медаль авч нийт багийн дүнгээр Шилжин явах цом авсан амжилттай оролцсон. Боомтын захиргааны байгууллагаас зохион байгуулсан төрийн байгууллагуудын тэмцээнд байгууллагаа төлөөлөн оролцож 2-р байр эзэлсэн. Алба хаагчдын зохион байгуулсан сургалт, семинариудад тухай бүрт хамрагдсан.	03.07 - 11.29	90
11.	Арга хэмжээ 4.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах	Архивласан баримт бичгийн тоо	-	100%	Журмын дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байна. Тайлант хугацаанд алба хаагчдаас ирүүлсэн архивын бичгийг хүлээн авч, архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрдлийг ханган, алдаатай архивын баримт бичгийг дахин бүрдүүлж ажилласан. Шаардлагатай тохиолдолд албан бичиг боловсруулж зохих ажилтанд хүргүүлж ажилласан. Ульхан, Эрээнцав боомтод ажиллах хугацаанд ээлж хүлээлцсэн актыг тухай бүр үйлдэж, боомтын үйл ажиллагааны	03.07 - 11.29	80

1	2	3	4	5	6	7	8
					өдөр тутмын мэдээг үйл ажиллагааны дэвтэрт хөтлөн, бүртгэл дууссан авто зам, боомтын хөдөлгөөний дэвтэр болон өмнөх алба хаагчдын ажил хүлээлцсэн актыг боомтоос бүсийн төвд төвлөрүүлэн, холбогдох ажилтанд хүлээлгэн өгч ажилласан.		
12.	Арга хэмжээ 4.4. Бүсийн нийт албан хаагчдад "Санхүүгээ зөв удирдах" сэдэвт сургалт зохион байгуулах	Ажлын биелэлтийг танилцуулсан илтгэх хуудсын тоогоор	-	100%	2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр бүсийн газарт "Санхүүгээ зөв удирдахуй-Өрхийн хуримтлал" сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад танхимаар 11, цахимаар 9 нийт 20 албан хаагч хамрагдаж, сургалтын үр дүнг илтгэх хуудсаар танилцуулсан.	03.07 - 11.29	90
13.	Арга хэмжээ 4.5. Хилийн боомтын амьдрах байр, ажлын байрны орчин нөхцөл сайжруулах	Хийгдсэн ажлын биелэлт	-	100%	Ульхан боомтын ажилласан хугацаанд амьдрах байрны гадна зэрлэг өвс болон хатсан өвсийг зулгааж, дараагийн албан хаагчид хүлээлгэж өгөхдөө амьдрах байрыг цэвэрлэн, хүлээлгэж өгсөн. Эрээнцав боомтод ажилласан хугацаанд амьдрах байрны гадна хог дүүрсэн байсныг цэвэрлэж, өдөр тутамд тарьмал цэцэг, моддыг тордож арчилсан. Мөн ажлын байрны цэвэрлэгээг өдөр тутамд хийж дараагийн алба хаагчид хүлээлгэн өгсөн.	03.07 - 11.29	80


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. Англи хэлний сургалтад хамрагдаж түвшин ахиулах	Англи хэлний түвшин ахиулсан байна.	-	100%	Англи хэлний түвшин ахиулах B1 ангиллын сургалтад хамрагдаж Intermediate түвшний сертификат эзэмшсэн.	03.07 - 11.29	100
2.	Арга хэмжээ 2.2. Комьпютерт Монгол бичгээр шивэх цахим бичвэрийн сургалтад хамрагдах	Судалсан сургалтын сэдэв, сертификатын тоо	-	1	Монгол бичгээр комьпютерт шивэх бичвэрийн сургалтад цахим болон танхимын сургалтад хамрагдаж сертификат эзэмшсэн.	03.07 - 11.29	100
3.	Арга хэмжээ 2.3. Удирдлагын академийн 4 сэдэвт цахим сургалтад хамрагдаж сертификат авах	Судалсан сургалтын сэдэв, сертификатын тоо	-	12	Удирдлагын академийн сургалт болох "Монгол бичиг", "Хүний эрх", "Авилгалаас ангид төрийн алба", "Ёс зүй" сэдвүүдийн I, II, III түвшний сургалтуудад бүрэн хамрагдаж сертификат эзэмшсэн.	03.07 - 11.29	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

И.НОМИНЗУЛ

2024 оны 12 сарын 05



"МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭР" ТББ

СЕРТИФИКАТ

Ц. Намсруу

ТАНД

**ЦАХИМ БИЧВЭРИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАЖ
ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ ДЭЭР МОНГОЛ БИЧГЭЭР
БИЧИХ АРГА ЗҮЙ ЭЗЭМШСЭН ТУЛ СЕРТИФИКАТ ОЛГОВ.**

ТББ-ЫН ТЭРГҮҮН



Инхжаргал

Б.ЭНХЖАРГАЛ

2024 ОНЫ 11...САРЫН 24... ӨДӨР



CERTIFICATE

OF COMPLETION

This certifies that

Iderkhuu Nominzul

has successfully completed 3
months

Intermediate level
English language course

December 2, 2024

Date Completed



O. Bilguun

Bilguun Ochirbat

Founder and Course Leader
bilostone@gmail.com

28